Таны Дүрвэгчийн орогнол хүссэн өргөдөл

Дүрвэгсдийн Ерөнхий процедурын тухай мэдээлэл

Та яагаад энэ товхимолыг хүлээж авав?
Та Нидерландын Вант улсад орогнол асуухыг хүсэж байна. Дүрвэх гэдэг нь: эх орондоо аюул заналд учирсан хүмүүс өөрийн эх орноосоо хамгаалалт авч чадахгүйн улмаас өөр улсаас хамгаалалт гуйхыг хэлнэ.

Хэрвээ та орогнол хүсэж өргөдөл өгвөл, Нидерландын Вант улсын засгийн газраас албан ёсоор оршин суух зөвшөөрөл асууж байна гэсэн үг юм. Нидерландын Вант улсад амьдрахад танд зөвшөөрлийн бичиг баримт хэрэгтэй. Таныг дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлөө өгсний дараа дүрвэгсдийн процедур эхэлнэ: энэ нь Нидерландын Вант улсын засгийн газар танд оршин суух зөвшөөрлийн бичиг өгөх эсэхийг шийддэг хууль эрх зүйн үйл ажиллагаа юм.

Энэ товхимолоос та дүрвэгсдийн процедур хэрхэн явагддаг тухай унших болно. Мөн таны хийх ёстой (таны үүргүүд) ба та Нидерландын Вант улсын засгийн газраас юуг хүсэмжилж болох (таны эрхүүдийн) тухай уншаарай.

Та ямар тохиолдолд дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авах вэ?

Нидерландын Вант улсын Гадаад иргэдийн тухай хуульд ямар болзлууд бүрдэж байж дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авч чадах тухай заасан байдаг. Дараах тохорхойлолтуудын аль нэг нь танд тохирч байвал та оршин суух зөвшөөрлийг авч чадна:

- Та арьсны өнгө, яс үндэс, шашин шүтлэг, гарал угсаа, улс төрийн үзэл бодлоос эсвэл ямар нэгэн нийгмийн бүлэглэлд хамаарагддагаас шалтгаалж эх орондоо мөрдлөг хавчлагын аюул заналд учирсан үндэслэлтэй шалтгаантай бол
- Та эх орондоо цаазаар авах ял ба аллагад өртөгдөх, тамлагдаж зовох эсвэл бусад хүнлэг бус эсвэл доромжлогдон гутаагдах аюулд тулгарсан үндэслэлтэй шалтгаантай бол
- Та эх орондоо зэвсэгт мөргөлдөөний хүчирхийллийн улмаас санаандгүй хохирогч болох аюулд тулгарсан ба үндэслэлтэй шалтгаантай бол
- Таны нөхөр/эхнэр, хамтрагч, аав ээж эсвэл насанд хүрээгүй хүүхэд тань саяхан Нидерландын Вант улсын дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авсан бол.

Immigratie- en Naturalisatiedienst (IND) – Дүрвэгсдийн – ба Иргэншлийн.
Асуудлыг Хариуцсан Байгууллага (ИНД) таныг дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийн бичгийн болзлуудыг хангаж буй эсэхийг шийдвэрлэдэг.

Хэрвээ та Нидерландын Вант улсын хил дээр аль хэдийн дүрвэгсдийн орогнол хүссэн бол (нисэх онгоцны буудал юмуу – усан онгоцны буудал дээр), таныг Нидерландын Вант улсад нэвтрэн орохыг хориглох боломжтой: энэ тохиолдолд та Нидерландын Вант улсад албан ёсоор орж ирж болохгүй. Мөн таны дүрвэгсдийн процедур нь энэ товхимолд зааснаас өөр юм. Хилийн процедурын талаар тусгайлан гаргасан товхимолоос судална уу.

Та ямар байгуулгуудад хандах вэ?

COA Centraal Orgaan opvang asielzoekers

Centraal Orgaan opvang asielzoekers (COA) – Дүрвэгсдийг Хүлээн Авах Төв Байгууллага (COA) нь Нидерландын Вант улс дахь дүрвэгсдийг хүлээн авах ба үүнтэй холбоотой асуудлуудыг хариуцдаг. COA таныг хоол, байраар хангах ба эрүүл мэндийн зардлын даатгалтай болоход тусалдаг. Та эмчтэй холбогдож тусламж авахаар бол COA-д хандаж болно. COA бол биеэ даасан байгууллага ба таны дүрвэгчийн асуудлыг шийдэхгүй. www.coa.nl

gza healthcare

GezondheidsZorg Asielzoekers (GZA) – Дүрвэгсдийн Эрүүл Мэндийн (GZA) байгууллагад та өвдсөн үедээ болон эрүүл мэндтэйгээ холбогдолтой асуултынхаа талаар хандаж болно. COA-гийн байр болгоны ойролцоо GZA-ийн төв байрладаг. GZA нь танд эмчийн туслахтай, сувилагч нартай, GGZ- ийн эмчилгээний туслахуудтай болон өрхийн эмчтэйгээ цаг авч уулзахад танд тусалдаг. www.gzasielzoekers.nl

VluchtelingenWerk Nederland

VluchtelingenWerk Nederland – Нидерландын ДүрвэгсдийнАжил бол биеэ даасан хүний эрхийг хамгаалах байгууллага бөгөөд дүрвэгсдийн эрх ашгийг хамгаалахын тулд байгуулагдсан юм. VluchtelingenWerk ДүрвэгсдийнАжил танд болон дүрвэгсдийн процедурын тухай тайлбар ба мэдээлэл өгдөг. Таныг процедураа туулахад, хувийн мэдээллийг тань лавлаж өгөх ба өөр байгуулгуудтай үүссэн асуудлуудыг тань зохицуулж өгөхөд VluchtelingenWerk тусалдаг. Тэд энэ үйл ажиллагаандаа таны өмгөөлөгчтэй хамтран ажилладаг. VluchtelingenWerk таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд шийдвэр гаргахгүй.
www.vluchtelingenwerk.nl | www.forrefugees.nl

Raad voor Rechtsbijstand
legal aid

Raad voor Rechtsbijstand – Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар таныг өмгөөлөгчийн тусламж авааД зардлыг нь төлж чадахгүй тохиолдолд тусалдаг. Өмгөөлөгчийн танд үзүүлсэн үйлчилгээний хөлсийг Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар өмгөөлөгчид төлдөг. Өмгөөлөгч бол Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газрын ажилтан биш юм. Өмгөөлөгч бол таны дүрвэгсдийн процедурт туслалцаа үзүүлэх биеэ даасан хууль эрх зүйн тусламж үзүүлэгч юм. www.rvr.org

Immigratie- en Naturalisatiedienst
Ministerie van Justitie en Veiligheid

Immigratie- en Naturalisatiedienst (IND) – Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага (ИНД) нь Нидерландын Вант улсын Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яамны харъяа байгууллага юм. IND-гийн ажилчид таныг хэн болох, таны иргэншил харъяалал, ирэхдээ туулсан зам, эх орноосоо дүрвэн гарсан шалтгааны тухай таньтай ярилцдаг. Тэгээд тэд таны хувийн түүхийг болон эх орны тань нөхцөл байдлыг судалдаг. Дараа нь тэд таныг Нидерландын Вант улсад (түр хугацаанд) үлдэж болох эсвэл эх орондоо буцах ёстой эсэхийг шийдвэрлэдэг. www.ind.nl

BEVELIGING

IND ба COA-гийн хүлээн авах төвийн барилгуудад **хамгаалагч** нар байдаг. Та тэднийг дүрэмт хувцсаар нь таньж болно. Тэд таны аюулгүй байдлыг хангадаг. Та тэднээс IND ба COA-гийн барилгуудад болон талбайд ямар зүйлс зөвшөөрөгдсөн болон хориотой байдгийг асууж болно. Эдгээр хамгаалагчид таны дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэхэд нөлөө үзүүлэхгүй.

Dienst Terugkeer en Vertrek
Ministerie van Justitie en Veiligheid

Dienst Terugkeer en Vertrek (DT&V) – Эх оронд нь буцаах болон буцах байгууллага (DT&V) нь Нидерландын Вант улсын Хууль Зүй ба Батлан Хамгаалах яамны харъяа байгууллага юм. Хэрвээ IND таны орогнол хүссэн өргөдөлд татгалзсан хариу өгсөн бол, таныг эх орондоо харихтай холбоотой зохион байгуулалтад DT&V байгууллагын ажилтан танд тусалдаг.
www.dienstterugkeerenvertrek.nl

INTERNATIONAL ORGANIZATION FOR MIGRATION
IOM·OIM
THE UNITED NATIONS MIGRATION AGENCY

Internationale Organisatie voor Migratie (IOM) – Олон Улсын Дүрвэгсдийн Төлөөх Байгууллага (IOM) – бол биеэ даасан дэлхий даяар дүрвэгсдэд тусалдаг байгууллага юм. IOM таныг өөрөө сайн дураараа Нидерландын Вант улсыг орхин гарах бол тусалж чадна. IOM таныг буцахад болон дахин эх орондоо эргэн зохицоход тань хэрэгтэй бодит мэдээллийг өгч Нидерландын Вант улсаас явах бэлтгэлээ хангахад тань тусалдаг. Та мөн VluchtelingenWerk – (ДүрвэгчдийнАжил) байгууллага эсвэл өмгөөлөгчөөсөө тусламж гуйж болно.
www.iom-nederland.nl

Танаас юу хүлээж байна вэ?

Дүрвэгсдийн процедурын үеэр та мэдүүлэг өгөхдөө орогнол хүссэн шалтгаанаа сайн тодорхойлон бататгах нь их чухал юм. Мөн танаас бүхий л өөртөө байгаа эсвэл олж авч бүрдүүлж чадах (жишээ нь таны хувийн бичиг баримтууд эсвэл таны мэдүүлгийг батлах захидлууд, гэх мэт) нотлох баримтуудыг IND-д харуулахыг хүсдэг.

IND-д таныг харгалзан авч үзэх хувийн нөхцөл байдал байна уу? Түүнийгээ мэдэгдээрэй. Үүнд чинь үндэслээд IND ярилцлагын үеэр ч юм уу эсвэл COA-гийн хүлээн авах төвдөө арга хэмжээ авч чадах юм. IND танд аль болох туслахыг хичээх болно.

Дүрвэгсдийн процедур өдөр өдрөөр хэрхэн өрнөдөг вэ

IND-тэй тохирсон цагтаа та IND-гийн байранд очно. Эндээс таны Ерөнхий дүрвэгсдийн процедур эхэлж байна.

Та процедуртаа бэлдэж байхдаа байсан байрандаа дүрвэгсдийнхээ процедурын явцад үргэлжлүүлэн байрлаж болох боломжтой. Зарим үед таны амрах болон процедуртаа бэлдэх хугацаа дуусангуут IND-гийн кантоортай ойрхон хүлээн авах төв уруу таныг нүүлгэнэ.

IND-д ярилцлагад орох бол таныг IND-гийн байранд хүргэж өгдөг. Ойрхон байрлаж байгаа бол та алхаад очиж бас болно.

Үүний дор та дүрвэсдийн процедур өдөр өдрөөр хэрхэн явагддаг талаар унших болно.

1 дэх өдөр: анхны ярилцлага
Ерөнхий дүрвэгсдийн процедурын явцад IND-тэй хийх эхний ярианд анхны ярилцлага гэж нэрлэдэг. Энэ ярилцлагын үеэр IND бүртгэлийн ярилцлагад өгсөн мэдээллийг шалгадаг. Тодорхойгүй зүйлүүд байвал IND бас нэмэлт асуултууд асуудаг. Энэ ярилцлаганд танаас дүрвэх болсон шалтгааны тухай асуултууд асуудаггүй. Тэр талаар дараа нь (өдөр 3-ыг харна уу) IND-гийн ажилтантай хийх ярилцлагын үеэр ярилцана. Хэрвээ та хүсвэл VluchtelingenWerk-ДүрвэгсдийнАжил байгууллагыг анхны ярилцлагадаа хамт байлгахаар асууж болно. Үүнийг өмгөөлөгчөөрөө дамжуулан зохицуулж болно.

IND-тэй ярилцах ярилцлагад хэлмэрч байх болно. IND-гийн ажилтан Нидерланд хэлээр асуултууд асууна. Хэлмэрч тэдгээр асуултуудыг таны ойлгодог хэл рүү хөрвүүлнэ.
Хэлмэрч мөн таны хариулсан хариултуудыг Нидерланд хэл рүү хөрвүүлнэ. Хэлмэрч бол биеэ даасан ажилтан бөгөөд таны дүрвэгчийн асуудлыг шийдэхэд нөлөө үзүүлэхгүй. Хэрвээ хэлмэрч та хоёр бие биенээ сайн ойлголцохгүй байгаа бол таүтэр даруй мэдэгдээрэй. IND танд өөр хэлмэрч олж өгнө. Та асуултаа сайн ойлгоогүйгээс болж тэнд буруу ойлголт үүсэхгүй байх нь чухал юм.

Хэрвээ та нөхөр/эхнэртэйгээ буюу хамтран амьдрагчтайгаа хамтдаа орогнол асууж өргөдөл өгсөн бол, та бүхэн тус тусдаа IND-гийн ажилтанд ярилцлага өгнө. Хэрвээ та 15 настай буюу түүнээс дээш насны хүүхдүүдтэй бол тэд ч мөн тус бүрдээ өөрийн ярилцлага өгнө. Та анхны ярилцлагын тайланг шууд IND-гээс юмуу өмгөөлөгчөөрөө дамжуулан хүлээн авна.

2 дахь өдөр: дараагийн ярилцлагадаа бэлдэх
Анхны ярилцлагын тайлангийн тухай та өмгөөлөгчтэйгөө хэлэлцэнэ. IND-гийн кантоорт өмгөөлөгчтэй ярилцахад зориулагдсан тусгай өрөө байх болно. Энэ ярилцлагын үеэр өмгөөлөгч болон танд хэлмэрчилж туслах хэлмэрч байх болно. Хэрвээ тайланд дутуу бичигдсэн ба алдаатай зүйлс байвал өмгөөлөгч бичгээр IND-д мэдэгддэг. Таны өмгөөлөгч таныг IND –тэй хийх хоёр дахь ярилцлагад бэлдэнэ.

3 дахь өдөр: гүнзгийрүүлсэн ярилцлага
Ерөнхий дүрвэгсэдийн процедурын явцад IND-тэй хийх хоёр дахь ярилцлагыг гүнзгийрүүлсэн ярилцлага гэж нэрлэдэг. Энэ ярилцлагад та орогнол асуух болсон шалтгаанаа ярина. Энэ ярилцлагын үеэр IND-гийн ажилтан танаас асуултууд асуух болно.

Энэ ярилцлага нь мөн IND-гийн кантоорт явагддаг. Танд яагаад хамгаалалт хэрэгтэй байгаа бүх учраа ярих нь их чухал юм. Танд юу тохиолдсон болон ямар шалтгаанаар та эх орноосоо хамгаалалт авч чадахгүй байгаагаа та шударгаар, бүрэн гүйцэд, ойлгомжтой яриарай. Хэрвээ та ямар нэгэн болсон үйл явдлыг сайн санахгүй байгаа бол IND-гийн ажилтанд тайлбарлаж хэлээрэй. IND-гийн ажилтан таны эх орны нөхцөл байдлын талаар ерөнхий ойлголттой байгаа. Гэвч та өөрийнхөө хувийн нөхцөл байдлын талаар ярих нь чухал юм: Ер нь яагаад танд хувь хүний хувьд хамгаалалт хэрэгтэй байгаа юм бэ. Та аль болох түүхтэйгээ хамааралтай мэдээллийг нарийвчилж ярих хэрэгтэй. Хэрвээ танд таны дүрвэх болсон шалтгаантай холбоотой шарх сорви, бие махбодийн болон сэтгэл санааны зовуурь байгаа бол үүнийгээ IND-гийн ажилтанд хэлж байх нь чухал юм. Хэрвээ IND таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг шийдвэрлэхэд шаардлагатай гэж үзвэл, танд шүүх эмнэлгийн үзлэг хийх санал болгож болно. Та бас өөрийн санаачилгаар, өөрийн зардлаар ийм үзлэгийг хийлгэх боломжтой юм.

Энэ ярилцлагад ч хэлмэрч байдаг. Хэрвээ та хүсвэл VluchtelingenWerk-(ДүрвэгчдийнАжил) байгууллагыг ярилцлагадаа байлгахыг хүсэж болно. Үүнийг та мөн өмгөөлөгчөөрөө дамжуулан зохицуулж болно.
Та (өмгөөлөгчөөрөө дамжуулан) энэ ярилцлагын тайланг хүлээж авна.

4 дэх өдөр: гүнзгийрүүлсэн ярилцлагын талаар хэлэлцэх

Таны өмгөөлөгч таньтай гүнзгийрүүлсэн ярилцлагын тайлангийн тухай хэлэлцэнэ. Энэ ярилцлагад ч хэлмэрч өмгөөлөгчийн болон таны хэлсэн болгоныг хөрвүүлж тусална. Хэрвээ тайланд дутуу бичигдсэн болон алдаатай зүйлсүүд байвал өмгөөлөгч бичгээр IND-д мэдэгддэг.

5 дахь өдөр: урьдчилсан шийдвэр

Таныг IND дүрвэгсдийн оршин суух зөвшөөрөл авах болзлыг хангаж буй эсэхийг дүгнэнэ.

Энэ дүгнэлтээс гарах шийдвэр нь таны дүрвэгсдийн процедур цаашдаа яаж явагдахыг тодорхойлдог.

Энд гурван боломж бий:

1. Та дүрвэгсдийн оршин суух зөвшөөрөл авах болзлыг хангасан тохиолдолд. Танд (өмгөөлөгчөөр тань дамжуулж) IND захидал (=beschikking) (шийдвэр) өгнө. Энэ захидалд таны орогнол хүссэн өргөдлийн хариуд зөвшөөрсөн хариу өгсөн тухай бичигдсэн байна. Та (түр хугацаанд) Нидерландын Вант улсад үлдэж болно. Өмгөөлөгч танд энэ нь ямар үр дагавар авчрах тухай тайлбарлаж өгнө.
2. IND-д судалгаа явуулахад илүү хугацаа хэрэгтэй байгаа тул найман хоногийн дотор таны орогнол хүссэн өргөдлийг шийдвэрлэж чадахгүй гэнэ. IND үргэлжлүүлэн таны дүрвэгсдийн өргөдлийг Дүрвэгсдийн Уртасгасан Процедурээр шийдвэрлэнэ. Таны орогнол хүссэн өргөдлийн хариу дараа нь гарна. Та Дүрвэгсдийн Уртасгасан Процедурын талаар тусгай товхимол хүлээн авна.
3. IND таныг дүрвэгчийн орогнол хүссэн оршин суух зөвшөөрлийг авах болзлыг хангахгүй байна гэсэн шийдвэр гаргах үед. IND (өмгөөлөгчөөр дамжуулан) таны дүрвэгчийн орогнол хүссэн өргөдөлд татгалзах төлөвлөгөөтэй байна гэж бичсэн захиа өгнө. Энэ нь захидлыг урьдчилсан шийдвэр гэж нэрлэдэг. Энэ захидалд татгалзсан хариу өгөх болсон шалтгаануудыг дурдаж танд мөн энэ нь ямар үр дагавар авчирахыг заасан байна. Өмгөөлөгч таньтай уг захидлын талаар хэлэлцэнэ.

6 дахь өдөр: үзэл бодол

Хэрвээ IND таны орогнол хүссэн өргөдөлд татгалзах төлөвлөгөөтэй байгаа бол, та өмгөөлөгчтөйгөө урьдчилсан шийдвэрийн талаар ярилц. Таны өмгөөлөгч таньтай урьд нь энэ талаар ярилцаж тохирсон байх ёстой. Үргэлжлүүлэн таны өмгөөлөгч IND-д бичгээр үзэл бодлоо илэрхийлнэ. Энэ захидалдаа IND-гийн гаргасан урьдчилсан шийдвэрийг албан ёсоор эсэргүүцэж мөн ямар шалтгаанаар эсэргүүцэж байгаагаа дурдсан байна.

7 ба 8 дахь өдөр: шийдвэр

IND таны илгээсэн үзэл бодлыг уншсаны дараа урьдчилан гаргасан шийдвэрээ өөрчлөх эсэхийг шийддэг. Эндээс гарсан шийдвэр дахиад таны дүрвэгсдийн процедур хэрхэн явагдахыг тодорхойлно. IND гаргасан шийдвэрээ захиагаар танд (өмгөөлөгчөөр тань дамжуулан) мэдэгдэнэ. Таны өмгөөлөгч танд энэ шийдвэр ямар үр дагавартай болохыг тайлбарлаж өгнө. Энд гурван боломж бий:

1. IND таны илгээсэн үзэл бодлыг уншаад дараа нь таныг дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авах болзлыг хангаж байна гэж үзэх. IND танд захиа буюу шийдвэр (=beschikking) танд (өмгөөлөгчөөр тань дамжуулан) өгнө. Энэ захидалд таны орогнол хүссэн өргөдлийн хариуг зөвшөөрсөн гэж бичсэн байна. Та (түр хугацаанд) Нидерландын Вант улсад оршин сууж болно. Таны өмгөөлөгч танд энэ нь ямар өөр үр дагавар авчирч байгааг тайлбарлаж өгнө.
2. IND-д судалгаа явуулахад илүү хугацаа хэрэгтэй байгаа тул найман хоногт таны орогнол хүссэн өргөдлийг шийдвэрлэж чадахгүй. IND таны орогнол хүссэн өргөдлийг цаашид Дүрвэгсдийн Уртасгасан Процедурээр шийдвэрлэнэ. Таны орогнол хүссэн өргөдлийн хариу дараа нь гарна. Та мөн Дүрвэгсдийн Уртасгасан Процедурын талаар товхимол авна.
3. IND гаргасан шийдвэрээ үлдээж таныг дүрвэгчийн орогнол хүссэн оршин суух зөвшөөрөл авах болзлыг хангахгүй байна хэмээн шийдвэрлэх. Танд (өмгөөлөгчөөр тань дамжуулан) IND таны дүрвэгчийн орогнол хүссэн өргөдлийн хариуд татгалсан гэж бичсэн (шийдвэр) захиа өгнө. Энэ шийдвэрт татгалзсан хариуны шалтгаанууд болон энэ нь танд ямар үр дагавартай болохыг дурдсан байна. Мөн энэ шийдвэрийн эсрэг ямар арга хэмжээ авч болох болон буцах ямар боломжууд байгааг дурдсан байна. Таны өмгөөлөгч захидлын тухай таньтай хэлэлцэнэ.

Гаргасан өргөдлөө буцаан татан авах

Та гаргасан өргөдлөө хүссэн үедээ буцааж авч болно. Энэ тохиолдолд таныг өмгөөлөгчтэйгөө уулзахыг зөвлөдөг боловч шууд IND-д хандаж ч бас болдог. Хэрвээ та IND-гээс өргөдлөө буцаан авбал танд энэ улсад өөр шалтгаанаар оршин суух эрх байхгүй л бол Нидерландын Вант улсад байж болохгүй болдог. Та орогнол хүссэн өргөдлөө буцаан татан авч байна уу? Тэр үед танд хилээр нэвтрэн орох хориг авах боломжтой. Үүний улмаас та Европын ихэнх орнуудад амьдрах болон эдгээр орнуудаар зорчин явах боломжгүй болно. Танд хилээр нэвтрэх хориг тавьсан байсан ч гэсэн та орогнол хүссэн өргөдлөө цуцалсныхаа дараа дахин орогнол хүсэх боломжтой.

Дүрвэгсдийн процедур дууссаны дараа

Та ерөнхий Дүрвэгсдийн процедурын дараа COA-гийн өөр байр уруу нүүх болно.

Та оршин суух эрх авлаа
Хэрвээ IND таны дүрвэгсдийн өргөдлийн хариуд зөвшөөрвөл та (түр хугацаанд) Нидерландын Вант улсад оршин сууж болно. Та оршин суух зөвшөөрлийн бичиг хүлээн авна, та ажил хийж болно, мөн гэр бүлийнхээ гишүүдийг ч авчруулж болно.
Үүнээс гадна COA орон сууц олоход зуучилж өгдөг. Тогтмол оршин суух байрны холбогдолтой чухал мэдээллийг COA-тай ярилцахдаа тодорхойлж өгнө. Таны энэ мэдээлэл нь Нидерландын Вант улсын аль нэгэн хотын захиргаанд холбогддог. Үргэлжлүүлэн хотын захиргаа танд тохиромжтой байр хайж өгдөг. Танд ганцхан удаа л орон сууц санал болгодог. Та үүнийг хүлээн авах ёстой. Та байраа олтлоо COA-гын орогнох төвд амьдарч болно. Таныг зөвшөөрсөн хариу авсны дараа IND таны эрх ба үүргүүдийн тухай мэдээлэл өгдөг. VluchtelingenWerk- (ДүрвэгчдийнАжил) байгууллагын ажилтнууд таныг Нидерландын Вант улсын нийгэмд дасан зохицоход тусална. Тэд мөн танд төрөл бүрийн байгууллагуудтай холбогдоход, тухайлбал орон сууц олоход, сургууль, ажилд ороход тусална.

Та оршин суух эрх авсангүй
Хэрвээ IND таны орогнол хүссэн өргөдөлд татгалзвал, та өмгөөлөгчтөйгөө хэлэлцээд Нидерландын Вант улсын шүүгчид энэ шийдвэрийн эсрэг давж заалдаж болно.
Энэ нь та шүүгчид IND- гийн гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаагаа албан ёсоор илэрхийлж байна гэсэн үг юм. Ихэвчлэн давж заалдах процедураа та Нидерландад хүлээж болдог. Хэрэв та хүлээж болохгүй бол шүүгчээс давж заалдах процедурын үеэр Нидерландын Вант улсад үлдээж өгөхийг асууж болно. Үүнд таны өмгөөлөгч тусалж чадна. Шүүгч үргэлжлүүлэн IND Нидерландын Вант улсын хуулийн дагуу таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг шийдсэн эсэхийг судална. Танд тэнд Нидерландын Вант улсыг орхин гарах бэлтгэлээ хангахад зарчмын дагуу ихэнхдээ 28 хоногийн хугацаа өгнө. Энэ хугацаа өнгөрмөгц танд олгосон байранд амьдрах эрхгүй болно. Мөн та дүрвэгсдийн төвд байж болохгүй.

Буцах
Та эх орондоо буцах хариуцлагыг өөрөө хүлээнэ. Хэрвээ та заасан хугацаанд өөрөө санаачлагаараа буцахгүй бол таныг албадан эх оронлуу тань буцаана.
Dienst Terugkeer en Vertrek (DT&V)- Эх оронд нь буцаах болон буцах байгууллага (DT&V) нь таныг буцах үйл ажиллагаанд тусалдаг.
Хэрвээ та эх орондоо санаачлагаараа буцах хүсэлтэй бол, Internationale Organisatie voor Migratie (IOM)- Олон Улсын Дүрвэгсдийн Төлөөх Байгууллагатай холбоо барьж болно. IOM таныг буцахад тусалж хэрэгтэй мэдээлэл өгнө. Ихэнх дүрвэгсдийн төвүүд дээр IOM-той ярилцах цаг авч болдог. Таны Дүрвэгсдийн процедур дууссан ч гэсэн та VluchtelingenWerk – (ДүрвэгчдийнАжил) байгууллагаас тусламж болон мэдээлэл авч болно.

Хэрвээ та эх орондоо санаачлагаараа буцах хүсэлтэй бол, Internationale Organisatie voor Migratie (IOM)- Олон Улсын Дүрвэгсдийн Төлөөх Байгууллагатай холбоо барьж болно. IOM таныг буцахад тусалж хэрэгтэй мэдээлэл өгнө. Ихэнх дүрвэгсдийн төвүүд дээр IOM-той ярилцах цаг авч болдог. Таны Дүрвэгсдийн процедур дууссан ч гэсэн та VluchtelingenWerk – (ДүрвэгчдийнАжил) байгууллагаас тусламж болон мэдээлэл авч болно.

Хувь хүний мэдээллийн боловсруулалт

Хувь хүний мэдээлэл бол таны талаарх янз бүрийн мэдээлэл юм. Энэ товхимолын доор бидэнтэй хамтран ажиллаж буй байгууллагуудын нэрсүүд байгаа. Эдгээр байгууллагууд таны өргөдөл, мэдэгдэл эсвэл хүсэлтийг боловсруулах явцдаа таны хувийн мэдээллийг ашигладаг. Танаас тэд таны мэдээллийг асуугаад хэрвээ шаардлагатай бол бусад байгууллагууд, хүмүүсээс таны талаархи мэдээллийн талаар лавладаг. Эдгээр байгууллагууд таны өгөгдлийг ашиглаад, хадгалж, хуулийн дагуу шаардлагатай бол бусад байгууллагуудад мэдээллийг дамжуулдаг. Хувь хүний нууцлалын тухай хууль тогтоомжинд таны өгөгдлийг боловсруулдаг байгууллагуудын дагах ёстой үүргүүдийг заасан байдаг. Жишээлбэл, тэд таны өгөгдлийг анхааралтай, аюулгүйгээр боловсруулах ёстой. Хувь хүний нууцлалын тухай хуулинд мөн таны эрхийн талаар заасан байдаг, тухайлбал:

Та өөрийн хувийн мэдээллийн боловсруулалт болон өөрийн эрхийн талаар илүү ихийг мэдэхийг хүсч байна уу? Тэгвэл тухайн байгууллагуудын вэбсайтуудыг судлана уу.

Түгээмэл асуултууд

Ерөнхий дүрвэгсдийн процедур хэзээ эхлэх вэ?
Танд ирснээ бүртгүүлсний дараа Дүрвэгсдийн процедуртаа бэлдэх хамгийн багадаа л зургаан өдөр байгаа. Бодит байдал дээр дүрвэгсдийн процедур эхлэх хүртэл илүү удаан хүлээдэг. COA- гийн дүрвэгсдийг хүлээн авах төвд IND-д өгөх анхны ярилцлагын урилгыг танд өгдөг.

Би IND- гийн шийдвэр гартал хир удаан хүлээх ёстой вэ?
Ерөнхий Дүрвэгсдийн процедур ажлын найман өдөр үргэлжилдэг. Заримдаа IND ажлын найман өдөрт амжуулж шийдэж чаддаггүй. Жишээ нь таныг дүрвэгсдийн процедурын үеэр өвдөх тохиолдолд. Энэ тохиолдолд IND таны дүрвэгсдийн өргөдөлд шийдвэр гаргахын тулд ажлын зургаан өдөр нэмж авдаг. IND- гийн кантоор нь хагас- бүтэн сайн өдрүүдээр хаалттай байдаг: эдгээр нь ажлын өдрүүд биш юм. Мөн IND таны орогнол хүссэн өргөдлийг үргэлжлүүлж Дүрвэгсдийн Уртасгасан Процедурээр шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд IND таны орогнол хүссэн өргөдлийг хамгийн ихдээ зургаан сарын дотор шийдэх ёстой. Энэ хугацааг таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд гарын үсэг зурснаас эхэлж тоолно. Та тэгээд Уртасгасан Процедурын тухай шинээр товхимол хүлээж авна.

Хэрвээ IND зургаан сарын дотор шийдэж чадахгүй бол, IND–гээс танд мэдээ ирнэ. Хэрвээ та IND–д дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлөө өгснөөс хойш зургаан сараас илүү хугацаа өнгөрч, танд IND шийдвэрээ явуулаагүй ба IND–гээс мэдээ ирээгүй бол яах вэ? Та тэгвэл IND–ээс бичгээр хоёр долоо хоногийн дотор таны дүрвэгсдийн асуудлыг шийдэхийг шаардаж болно. Өмгөөлөгч тань үүнд тусалж чадна. Таны өмгөөлөгч шүүгчид хандасnаар IND-ээс шийдвэр гаргаагүй удсан хоног бүрээр торгуулийн мөнгө төлүүлэх боломжтой.

Би дүрвэх болсон түүхээ эмэгтэй хүнд ярих хүсэлтэй байна. Энэ болох уу?
Нидерландын Вант улсад та өдөр тутмын амьдралд эмэгтэй, эрэгтэй хүмүүстэй аль алинтай нь харьцахаас зайлсхийх аргагүй юм. Нидерландын Вант улсын нийгмийн тогтолцоонд эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш эрхтэй.
Таныг энэ эрхийг ч бас хүндлээсэй гэж бид хүсэж байна. Хэрвээ та үнэхээр эмэгтэй IND- гийн ажилтантай дүрвэх болсон учир шалгааныхаа тухай ярилцахыг хүсвэл, үүнийгээ IND-гийн анхны ярилцлаган дээр мэдэгдээрэй. IND мөн эмэгтэй хэлмэрчийг гүнзгийрүүлсэн (= хоёр дахь) ярилцлагын үеэр байлгахыг хичээх болно.
Та магадгүй эрэгтэй хүнд цагаачийн түүхээ яримаар байна уу? Үүнийгээ мөн л IND-гийн анхны ярилцлаган дээр мэдэгдээрэй. IND мөн л гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр эрэгтэй IND- гийн ажилтан ба хэлмэрч байлгахыг хичээх болно.

Хэрвээ би өвдвөл юу хийх ёстой вэ?
Хэрвээ та өвдсөн юмуу жирэмсэн бол эрүүл мэндийн үзлэгт орохдоо сувилагчид мэдэгдээрэй (товхимолыг хараарай: Дүрвэгсдийн процедурыг эхлэхээс өмнө). Хэрвээ та өөрийгөө сүрьеэ, хамуу, гепатит Б гэх мэтийн халдварт өвчтэй эсвэл та өвчтэй байх гэж таамаглаж байгаа бол үүнийгээ хэлэх нь маш чухал юм. Таны сувилагчид ярьсан болгон чинь нууцлагддаг. Таны зөвшөөрөлгүйгээр сувилагч эрүүл мэндийн талаарх мэдээллийг хэнд ч өгөхгүй. Хэрвээ та дүрвэгсдийн процедурынхаа үеэр өвдвөл COA, IND юмуу VluchtelingenWerk- (ДүрвэгчдийнАжил) байгууллагын ажилтангуудад мэдэгдээрэй. Тэд таныг зөв тохирсон (эрүүл мэндийн) тусламж авахад тусална. Хэрвээ та IND юмуу өмгөөлөгчтөйгөө уулзах өдрөө өвдвөл, COA- гийн ажилтнаас IND-д юмуу өмгөөлөгчдөө таныг өвчтэй байгааг дамжуулж хэлэхийг хүсээрэй.

Энэ товхимолыг уншсаны дараа танд асуух зүйл байна уу?
Танд асуултууд байгаа бол өөрийнхөө өмгөөлөгч юмуу COA, IND юмуу VluchtelingenWerk- (ДүрвэгчдийнАжил) байгууллагын ажилтангуудын нэгнээс нь асуугаарай.

Та гомдолтой байна уу?
Бүх дүрвэгсдийн процедуртай холбоотой ажилладаг байгуулгууд мэргэжлийн түвшинд, хянамгай ажилладаг. Хэрвээ та үнэхээр ямар нэгэн байгууллага танд муугаар хандсан гэж үзэж байгаа бол, гомдол мэдүүлж болно. Таны өмгөөлөгч юмуу VluchtelingenWerk- (Дүрвэгсдийн ажил) байгууллагын ажилтан танд туслах болно.

Энэ нийтлэлийг хамтран гаргасан:
Дүрвэгсдийг Хүлээн Авдаг Төв Байгууллага (COA)
Эх оронд нь буцаах болон буцах байгууллага (DT&V)
Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага (IND)
Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар (RVR)
НидерландынДүрвэгчдийнАжил байгууллага (VWN)
Гадаадын иргэдийн цагдаагийн алба, Танин тодорхойлох ба Хүний наймааны хэлтэс (AVIM)
Хааны Цагдаагийн Алба (Kmar)
Олон Улсын Дүрвэгсдийн Төлөөх Байгууллага (IOM)

Даалгавраар бичигдэв.
Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яам, Дүрвэгсдийн асуудал хариуцсан захиргааны www.rijksoverheid.nl

Энэ нийтлэлийн агуулгад зохиогчийн эрхийг түгээх боломжгүй. Хэрвээ орчуулгад утга санааны зөрөө гарвал Нидерланд хэл дээрхи нийтлэлийг дагана.